

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо<sup>1</sup> : 2020 оны 01 сарын 30  
Тендер шалгаруулалтын нэр: “Дизель түлш (3 багц)” нийлүүлэх  
Тендер шалгаруулалтын дугаар: МРЦМ/202012388

**“Монголпросцветмет” ТӨҮГ** эрх бүхий тендерт оролцогчдоос **Дизель түлш (3 багц)** нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь **50 000**<sup>2</sup> төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **[30]** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

- Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2018, 2019 оны жилийн эцсийн тайлан
- Аудитын тайлан ирүүлэх жилийн тоо: 2018, 2019 он
- Борлуулалтын хэмжээ: 2018, 2019 оны аль нэгд гүйцэтгэсэн борлуулалтын хэмжээ тендерт ирүүлсэн үнийн саналын мөнгөн дүнгийн 100%-иас багагүй байна.
- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Тендерт санал болгосон үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна.
- Туршлага: 2018, 2019 онд ижил төстэй бараа нийлүүлсэн туршлага бүрэн гүйцэтгэсэн болохыг тодорхойлсон өмнөх үйлчлүүлэгчийн тодорхойлолт, эсхүл гэрээ дүгнэсэн актын хамт. Гүйцэтгэгчээр ажилласан байх жилийн тоо: 2 жилээс багагүй (2018, 2019).
- Тусгай зөвшөөрөл шаардлагатай эсэх: Шаардлагатай

Тендерийн хамт

1-р багцад **185 831 000** төгрөгийн

2-р багцад **35 711 990** төгрөгийн тендерийн баталгааг ирүүлнэ.

Тендерийг 2020 оны 03 дугаар сарын 02 -ны өдрийн 15:00 цагаас өмнө [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар ирүүлэх ба мөн өдрийн 15:20 цагт цахим системээр нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: Зөвшөөрнө.

Дотоодын давуу эрх тооцох эсэх. Тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Улаанбаатар хот, БЗД 22-р хороо,  
Энхтайваны өргөн чөлөө – 98,  
405 тоот өрөө,  
утас: 450060 + 118**

<sup>1</sup> Тендерийн урилгыг анх зарлан мэдээлсэн өдөр байна.

<sup>2</sup> Тендерийн баримт бичгийг түүнийг бэлтгэхэд буюу хувилж олшруулах, шуудангаар хүргэх зэрэгт зарцуулсан өртгөөр үнэлж, тендер шалгаруулалтад оролцохыг хүсэгчдэд энэ үнээр саадгүй олгоно.